

11

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Р. Буянжаргал

Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагаас дэлхийн эдийн засгийн ойрын үеийн хөгжлийн чиг хандлагын талаар ээлжит танилцуулга гаргасан билээ. Дээрх байгууллагын судлаачдын үзэж байгаагаар дэлхий нийт аж ахуйн түвшинд зах зээлийн хөгжил удаашрах хандлага ажиглагдаж байгааг тэмдэглэсэн байна. Мөн АНУ-ыг идэвхтэй, санаачлагатай үйл ажиллагаагаа ойрын үед нэлээд идэвхжүүлэхийг харзнаж байна. Харин Европын бүс нутгийн орнуудын хөгжлийн дотоод эрэлт тогтворжих хандлага үгүйлэгдэж байгаа юм байна.

Дэлхийн эдийн засгийн хөгжлийн үндсэн чиг хандлагыг тодорхойлоход европын бүс нутгийн орнууд хүчтэй нөлөө үзүүлэх нь үнэнд нийцэж байна. Юуны өмнө Япон улсын дотоод асуудлыг үндсэнд нь сайжруулж ойрын үед хөгжлийн чиг хандлагыг эрүүлжүүлэх шаардлага тавигдаж байна. Эдийн засгийн хамтын ажиллагааны үр ашгийг харгалзан европын бүс нутгийн дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 2001 онд 2.6% өсгөх зорилтыг хүлээн зөвшөөрсөн. Харин энэ чиг хандлагыг европын орнуудын комиссын тооцоо судалгаатай харьцуулан үзэхэд тийм ч бодитой биш бөгөөд 2002 онд 2.8% өсгөхөөр төлөвлөсөн юм байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын төлөвлөснөөр европын бүс нутгийн орнуудын эдийн засгийг 2.7% өсгөхөөр төлөвлөжээ. Гэвч тус орны эдийн засгийн өсөлтийг 2002 онд 3% өсгөх боломж бий гэж судлаачид үзсэн байна.

Ер нь дэлхийн зах зээлийг тогворжуулан сайжруулах үндсэн чиглэл нь юуны өмнө санхүүгийн зах зээлийг тогтворжуулахад чиглэгдсэн алхам хийх шаардлага байна. Ер нь цаашдаа эдийн засгийн хөгжлийн байгууллагын бүрэлдэхүүнд багтдаг улс орнууд болон Америкийн төдийгүй дэлхийн аж ахуйн хувийн хэрэглээ, хувийн хөрөнгө оруулалтын зардлыг аль болох багасгах, хувьцааны ханшийг бууруулах хэрэгтэй болсон байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын судлаачид америкийн эдийн засгийн

хөгжил удааширч байгааг хүлээн зөвшөөрсөн боловч энэ байдал цаашдаа нэг их үргэлжлэхгүй байх гэсэн үзэл баримтлалтай байгаа юм байна. Үүнээс гадна гадаадын капиталын оролцоо багассанаар Америкийн төлбөрийн балансын алдагдал нэмэгдэж мэднэ гэж төлөвлөж байна.

Гэвч энэ үр дагавар нь дэлхийн эдийн засгийн байдалд төдийлөн нөлөөлж чадахгүй гэж үзэж байна. Тус байгууллагын судлаачид германы засгийн газрын баримталж байгаа улсын санхүүгийн бодлого арай дэндүү эрсдэлтэй байна гэж шүүмжилсэн байна.

Германы засгийн газар засаг захиргааны зардлаа эрс багасгах төсвийн алдагдлаа багасгахын тулд засгийн газраас тооцон төлөвлөсөн үр дүнг 1.5%-иас давуулахгүй байхаар тооцжээ. Үүний тулд засгийн газар улсын секторын үр өгөөжийг эрс дээшлүүлэх шийдвэр гаргах бүтцийн өөрчлөлтийг цаашид улам гүнзгийрүүлэх замаар эдийн засгийн чадавхаа дээшлүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна. Тус орны ажиллагсадын тооны өсөлт цаашид удаан хугацаанд дээшлэх хандлагатай байгаа юм байна. Ажлын өдрөөр ажиллах болсноор хөдөлмөрлөх хувь хэмжээг үндсэнд нь өсгөнө гэж үзсэн бололтой байна.

2001 онд Германы дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлт удааширч 2.2%-д хүрсэн бол 2002 онд дотоодын эрэлт нийлүүлэлтийг нэмэгдүүлснээр Германы эдийн засгийн өсөлтийн хурд нэмэгдэж 2.4%-д хүрэхээр төлөвлөсөн байна. Хөгжиж байгаа орнуудын дотроос зөвхөн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын эдийн засагчид Япон эдийн засгаа эрүүлжүүлэх бодлогоо хэрхэн биелүүлэхийг харзнаж байгаа юм байна. Харин 2002 оны өсөлт 3.9% хүрнэ гэж үзсэн байна. Дэлхийн эдийн засгийн зах зээлийг сэргээхэд Америкийн эдийн засгийг сайжруулах нь чухал нөлөө үзүүлнэ гэж үзэж байна. Олон улсын валютын сангийн төлөвлөснөөр Европын орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 2001 онд 2.4% 2002 онд нэмэгдэнэ гэж үзсэн байна.

Харин дээрх судлаачдын үзэж байгаагаар Германы эдийн засгийн хөгжлийн хурд 2.0%-иас давахгүй, Америкийн эдийн засгийн хөгжил 1.5% хавьцаа байна гэж үзэж байна. 2002 онд Америкийн нийт аж ахуйн зах зээлийг өөрчлөх бодлого явуулснаар дотоодын нийт бүтээгдэхүүн хэлбэрэлтгүй нэмэгдэж 2.5%-д хүрнэ гэж үзэж байна. Олон улсын валютын сангийн судлаачдын төлөвлөж байгаагаар Японы эдийн засгийн өсөлтийн хурд өнгөрсөн онд 0.6% байсан бол 2002 онд эрс өснө гэж үзэж байна. Мөн судлаачдын үзэж байгаагаар тус улс өнгөрсөн 10 жилд санхүүгийн секторын амин чухал асуудлуудыг оновчтой шийдвэрлэхийн тулд бүх боломжтой аргуудыг ашигласан гэж үзэж байна.

Олон улсын валютын сангийн судлаачдын санаа зовж байгаа нэг том асуудал нь аж үйлдвэр хөгжсөн тэргүүлэгч улс орнуудын зах зээл буурсаар байгаад байна. Мөн дагалдан нөлөөлж байгаа бас нэг гол асуудал бол хөгжиж байгаа томоохон орнуудын дунд шинээр аж үйлдвэржиж байгаа улс орон бас хөгжиж байгаа орнуудын экспорт хэрэглээний эрэлт буурч байгаа нь муугаар нөлөөлж байна.

ОУВСангийн тооцоогоор Ази болон Латин Америкийн улс орны эдийн засгийн өсөлтийг өмнөх үетэй харьцуулахад 2 дахин удааширсан гэж үзэж байна. Харин тус сангийн судлаачид Орос улсын эдийн засгийн хөгжилд нааштай үнэлгээ өгсөн байна.

Тус орны рублийн ханш бууралт нефтийн үнийн өсөлт тус орны төлбөрийн тайлан тэнцэлд нааштай нөлөөлснийг онцлон тэмдэглэсэн байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын боловсруулсан хүлээн зөвшөөрсөн аж үйлдвэр хөгжсөн зарим орны эдийн засгийн хөгжлийн үндсэн үзүүлэлтийн байдал төлөвийг доорх судалгаанаас ажиглаж үзье.

| Үзүүлэлт | 2000 | 2001 | 2002 |
|---|------|------|------|
| 1. Европын орнууд | | | |
| ДНБ | 3.4 | 2.6 | 2.7 |
| Инфляци | 1.2 | 2.2 | 2.1 |
| Ажилгүйдэл (идэвхтэй хүн амд %) | 9.0 | 8.3 | 7.8 |
| 2. Герман | | | |
| ДНБ | 3.0 | 2.2 | 2.4 |
| Хувийн хэрэглээ | 1.6 | 2.2 | 2.2 |
| Үндсэн капитал дахь нийт хөрөнгө оруулалт | 2.4 | 2.1 | 2.9 |
| Инфляци | -0.4 | 1.1 | 1.4 |
| Ажилгүйдэл (идэвхтэй хүн амд %) | 7.8 | 7.3 | 6.8 |
| 3. Америк | | | |
| ДНБ | 5.0 | 1.7 | 3.1 |
| Инфляци | 4.0 | 4.6 | 5.0 |
| Ажилгүйдэл (идэвхтэй хүн амд %) | 2.0 | 2.3 | 1.9 |
| 4. Япон | | | |
| ДНБ | 1.7 | 1.0 | 1.1 |
| Инфляци | 1.7 | 1.0 | 1.1 |
| Ажилгүйдэл (идэвхтэй хүн амд %) | 4.7 | 4.9 | 4.8 |

Эх үүсвэр: "Бику"